

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-11
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	12-29

---

<b>1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	12-15
<b>2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	15-21
<b>3.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	22-25
<b>4.Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл /Засгийн газар 2024.04.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</b>	25-27
<b>5.Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</b>	25 27-29

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 36 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Н.Энхболд;

Чөлөөтэй: П.Анужин, Д.Ганбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;

Тасалсан: Н.Алтанхуяг.

**Нэг.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Алтангэрэл, мөн газрын дэд дарга Д.Тэмүүлэн, Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ууганбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Ариунаа, Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Г.Анар-Эрдэнэ, Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Шадар сайд С.Амарсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэдалай, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1-2, 4-17 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба хариулж, тайлбар хийв.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“цэргийн болон цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдсан, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нэгжийг;” гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “тохиролцсоны дагуу” гэснийг “тохиролцож, саналыг бичгээр авсны дагуу” гэж өөрчилж, төслийн “4.5.Энэ хуулийн 4.4-т заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан тухайн цэргийн алба хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авна.” гэсэн хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “бусад” гэснийг хасаж, 5.3.5 дахь заалтын “хууль тогтоомж, зан заншлыг хүндэтгэн дагаж мөрдөх” гэснийг “хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил” гэж, 5.3.6 дахь заалтын “үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн” гэснийг “үүрэг гүйцэтгэх үеийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “төсөвт тусган, цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах” гэснийг “төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусламж, дэмжлэгийн” гэснийг, мөн 8.1.2 дахь заалтын “Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаарх сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон” гэснийг тус тус “энхийг дэмжих ажиллагаатай холбоотой” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “энхийг дэмжих” гэсний өмнө “гадаад улсад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “эгүүлэн татах” гэснийг “эгүүлэн татах ажлыг зохион байгуулах” гэж, 10.1.6 дахь заалтын “оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг” гэснийг “оролцох цагдаагийн алба хаагч, багийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн байгуулагдсан олон үндэстний цэргийн хүчний командлал” гэснийг “томилогдсон олон үндэстний цэргийн хүчний командлагч” гэж өөрчилж, 14.8 дахь хэсгийн “аливаа улстай байгуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

### **Хоёр.Найруулгын санал**

**Б.Энх-Амгалан:** 11.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “хаагчийг” гэснийг “хаагчдыг” гэж, 5 дугаар

зүйлийн 5.4 дэх хэсгийн “цэрэг, цагдаагийн” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч,” гэж, 5.5 дахь хэсгийн “алба хаагч болон цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “амь насаа алдсан” гэснийг “нас барсан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “алба хаагч, цэргийн” гэснийг “цэргийн алба хаагч,” гэж, 9.1.5 дахь заалтын “байдлыг” гэснийг “галаар” гэж, 9.1.11 дэх заалтын, мөн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “бие бүрэлдэхүүний” гэснийг “алба хаагчийн” гэж тус тус, 9.1.6, 9.1.9 дэх заалтын, мөн 10.1.4 дэх заалтын “7.1.7-д” гэснийг “7.1.6-д” гэж тус тус, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Батлан хамгаалахын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын” гэснийг “батлан хамгаалахын болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж тус тус өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын, мөн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн “цэрэг, цагдаагийн алба хаагч” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч” гэж, “цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн баг” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

**1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.26 дахь заалт нэмсүгэй.

“5.3.26.Цагдаагийн хөгжлийн сан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

***2.Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэнд” гэснийг “чөлөөлөгдсөн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ

***3.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***4.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***5.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэдалай, Зэвсэгт

хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 7.1.22 дахь заалтын “урамшууллыг” гэсний өмнө “мөнгөн” гэж, 2 дахь заалт буюу 8.1.11 дэх заалтын “дарамт шахалт” гэсний дараа “үзүүлэх” гэж тус тус нэмж, мөн заалтын “гадуурхалтаас ангид байх” гэснийг “гадуурхах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэх бүрэлдэхүүн,” гэсний дараа “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар,” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.3 дахь заалтын “...хилийн отряд, застав болон...” гэснийг “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

***Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

***Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:***

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төсөл /Засгийн газар 2024.04.23-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, мөн газрын дэд захирал Ж.Соёлмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, төслийн зөвшилцөх асуудлын талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг хэлэлцсэн тухай Байнгын хороодын хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Нарантуяа нар

оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, төслийн зөвшилцөх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 64.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 42 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 36 минут.

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц хүрсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн байна. Норовын Алтанхуяг ирсэн байна. Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна. Пүрэв-Очирын Анужин гишүүн арга хэмжээтэй байна, чөлөөтэй байна. Хавдисламын Баделхан гишүүн ирсэн байна. Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Баагаагийн Баттөмөр гишүүн ирсэн байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн ирж байна. Сүхбаатарын Батболд гишүүн өвчтэй байна. Дашдондогийн Ганбат гишүүн ирсэн байна. Бархүүгийн Дэлгэрсайхан гишүүн орон нутагт томилолттой байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна. Дамдины Цогтбаатар гишүүн орж ирж байна. Нямаагийн Энхболд гишүүн орон нутагт томилолттой байна. Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны өнөөдөр хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Засгийн газар 2024 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Засгийн газар 2024 оны 4 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн.

3.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ. Засгийн газар 2024 оны 4 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн.

4.Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн соёрхон батлах.

5.Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг зөвшилцөх тухай Засгийн газар 2024 оны 4 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийг дуудаарай.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл

**баримтлалын хүрээнд дэмжих эсэхийг хэлэлцье.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сайнбуянгийн Амарсайхан Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Шадар сайд, Лхамсүрэнгийн Алтангэрэл Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал, Долгорсүрэнгийн Тэмүүлэн Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа, Хурцын Ууганбат Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа, Эрдэнэдашийн Ариунаа Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч, Чойжамцын Бат-Очир Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч. Хуралдаанд оролцсон гишүүдийг оролцож байгаа ажлын хэсгийнхнийг танилцууллаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Амарсайхан сайдын микрофоныг өгье.

**С.Амарсайхан:** Байнгын хорооны эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 24 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд баталсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар төрийн тусгай хамгаалалт, түүнийг

хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг анх удаа хуульчлан тогтоосноос хойших өнөөдрийг хүртэлх хугацаанд улс орны эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон гадаад харилцаанд томоохон хөгжил, шинэчлэл, өөрчлөлтүүд гарсан тул энэхүү хуулийг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлага үүсэж байна гэж дүгнэлээ.

Түүнчлэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавих шаардлага, эрх зүйн баталгаатай холбоотой зохицуулалт нь төрийн албаны эрх зүйн шинэчлэлээс хоцорсон төдийгүй, сонгон шалгаруулах, томилох журмыг улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчимд нийцүүлэн нарийвчлан зохицуулах шаардлага үүсэж байна.

Иймд хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчдын хариуцлагыг өндөрдүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлэх чиглэлээр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 60 зүйлтэй боловсруулж, хуулийн төсөлд хуулийн зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зарим зүйл, хэсэг заалтын хэл зүй, найруулгыг ойлгомжтой тодорхой болгох үүднээс найруулгын шинжтэй зарим өөрчлөлтүүдийг давхар хийсэн болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлийг арилгах, төрийн тусгай



хамгаалалтын зорилго хуульчлан тодорхойлогдож, төрийн бусад хамгаалалтаас ялгамжтай байдал тодорхой болж, төрийн тусгай хамгаалалтад аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн шинжлэх ухааны хөгжил, техник, технологийн дэвшилийг хүний хүчин зүйлтэй хослуулсан, цаг үедээ нийцсэн, уян хатан хамгаалалтын арга хэлбэр, тактикаар хэрэгжих боломж бүрдэж, төрийн хамгаалалтын тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, алба хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага хариуцлагыг өндөрдүүлэх эрх зүйн баталгааг бүрдүүлэх нөхцөл боломж хангагдана гэж үзэж байна.

Хуулийн төсөлд бүх яамдын болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын саналыг авч, холбогдох саналыг тусгасан болно.

Иймд хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлүүлж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Шадар сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү.

Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна. Гишүүд үг хэлж, санал гаргаж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан одоо санал хураалт явуулна. Хэдэн хүн

байна? 1, 2, 3, 4. Ажлын хэсэг хүмүүсээ дуудаадаг.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Энэ бол хэлэлцэхийг дэмжих тухай хуулийн санал хураалт явуулах гэж байгаа учраас Хууль зүйн байнгын хороон дээрээс гишүүдийг дуудаадхаарай.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Тийм учраас энэ Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүд ээ болов уу? Нэг нь Баделхан гишүүнийх горимын санал гаргах уу? Баделхан гишүүн горимын санал гаргах уу? Баделхан гишүүний микрофоныг өгье.

**Х.Баделхан:** Сая энэ аппарат ажилласангүй. Дахин санал хураалгаж өгнө үү.

**Б.Энх-Амгалан:** Баделхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Энэ саналыг хүчингүй болгох саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Баделхан гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас түрүүний томъёоллоор буюу хуулиудыг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулиудыг үзэл баримтлалын хүрээний хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Чуулганы хуулийн хэлэлцсэн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Баделхан гишүүн танилцуулъя. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Томъёоллуудаа сайн, хурдан боловсруулаарай.

14.50 цаг

**Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан албан тушаалтнуудыг танилцуулъя. Ажлын хэсгийнхнийг оруулаадхаарай. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд

оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

1.Гүрсэдийн Сайханбаяр Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал, Чулуунбарын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Гомбосүрэнгийн Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа, Одоохүүгийн Ганбат Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа, Лхамдоржийн Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа, Байгалийн Эрдэнэдалай Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39-ийн дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Энэ нөгөө юутай нь тээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?



*Байхгүй байна.*

*Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Байхгүй байна.*

*Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 8 дугаар зүйл 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.*

*Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 асуулт асуугаадахъя. Хуулийн төслийн 3.1.2-т бие бүрэлдэхүүн гэж энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж, томилогдсон цэргийн болон цагдаагийн албан хаагчдыг гэж, 4.1 дээрээ энхийг дэмжих ажиллагаанд оролцож буй, оролцох бие бүрэлдэхүүн нь цэргийн болон цагдаагийн албан хаагч баг байна гэсэн ийм 2 ижил ийм агуулгатай ийм 2 хуулийн заалт байна. Үүнийг нэг ялгааг нь тайлбарлаадхаач. Яг ингээд уншихад бол яг энэ бие бүрэлдэхүүн, цэргийн албан хаагчийн баг гэдэг юм чинь бол нэг ийм*

болчхоод байна л даа. Тэгээд энэ дээр ажлын хэсэг юу бодож, яаж оруулж ирсэн юм? Хэн хариулах вэ? Жанжин штабын дарга хариулъя. Хэдэн номер юм? 3 номерын микрофон өгье. Яагаад гэвэл би протоколд үлдээх гээд байна л даа.

**С.Ганбямба:** Энх-Амгалан даргын асуултад хариулъя. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Ганбямба.

3 дугаар зүйлд байгаа бие бүрэлдэхүүн гэдэгт бол энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж байгаа, ажиллагаанд яваагүй байгаа бүрэлдэхүүн давхар хамаарч байгаа асуудал.

4 дүгээр бүлэг бол яг энхийг дэмжих ажиллагаанд ажиллагааны газар, орон дээр очоод энд бэлтгэлээ хангаад, бас бэлтгэлд байх явцад хасагдах бас тийм одоо тохиолдлууд байдаг. Эрүүл мэндийн шалтгаанаар, сахилга хариуцлагаар. Энэ 3.1.2-т байгаа бие бүрэлдэхүүн бүр тэр бэлтгэлд байгаа бүрэлдэхүүн орж байгаа учраас энэ энхийг дэмжих ажиллагаанд оролцогчоосоо ялгаатай юм гэсэн ийм томъёоллоор энэ 2 асуудлыг ялгаатайгаар авч үзэж болно.

4.1 нь бол яг НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд газар, орон дээрээ оччихсон байгаа цэргийн алба хаагчийг гэж. Хариулт дууслаа.

**Б.Энх-Амгалан:** Нэг нь бол бэлтгэгдэж байгаа, нөгөөх нь газар, орондоо очсон үүргээ гүйцэтгэж байгаа.

**С.Ганбямба:** Тийм бэлтгэж байгаа. Нөгөө нь газар орон дээрээ очоод, шийдвэр гараад үүрэг гүйцэтгэж байгаа. Ялгаатай нь энэ.

**Б.Энх-Амгалан:** Ойлголоо. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн бичгээр саналын томъёолол ирүүлсэн. Энэ саналын томъёолол нэг бүрээр тус бүрээр нь санал хураалт явуулъя. Энэ бол ажлын хэсэгтэй зөвшилцөж гаргасан саналын томъёолол тийм ээ?

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3. “цэргийн болон цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдсан, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нэгжийг;” гэж. Санал хураалт. Энэ бол найруулгын санал юм шиг байна даа. Энэ чинь өөрчлөн найруулж байгаа юм байна тээ?

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “тохиролцсоны дагуу” гэснийг “тохиролцож, саналыг бичгээр авсаны дагуу” гэж өөрчилж, төслийн “4.5.Энэ хуулийн 4.4-т заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан тухайн цэргийн алба хаагчид мэдэгдэж, саналыг бичгээр авна.” гэсэн хэсгийг хасах. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “бусад” гэснийг хасаж, 5.3.5 дахь заалтын “хууль тогтоомж, зан заншлыг хүндэтгэн дагаж мөрдөх” гэснийг “хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил” гэж, 5.3.6 дахь заалтын “үүрэг гүйцэтгэлтийн онцлогт нийцсэн” гэснийг

“үүрэг гүйцэтгэх үеийн” гэж өөрчлөх.  
Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “төсөвт тусган, цэрэг, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах” гэснийг “төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчлөх.  
Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “Монгол Улсаас оролцох боломжтой энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэл, тусламж, дэмжлэгийн” гэснийг, мөн 8.1.2 дахь заалтын “Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаа, энэ талаархи сургалт, бэлтгэлд оролцуулах болон хангалт, үйлчилгээтэй холбогдсон” гэснийг тус тус “энхийг дэмжих ажиллагаатай холбоотой” гэж өөрчилж, 8.1.3 дахь заалтын “энхийг дэмжих” гэсний өмнө “гадаад улсад” гэж нэмэх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “эгүүлэн татах” гэснийг “эгүүлэн татах ажлыг зохион байгуулах” гэж, 10.1.6 дахь заалтын “оролцуулах цагдаагийн баг, бие бүрэлдэхүүнийг” гэснийг “оролцох цагдаагийн алба хаагч, багийг” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар санал хураалт уг санал дэмжигдлээ.

7.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;” гэж. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжигдэж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

8.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн байгуулагдсан олон үндэстний цэргийн хүчний командлал” гэснийг “томилогдсон олон үндэстний цэргийн хүчний командлагч” гэж өөрчилж, 14.8 дахь хэсгийн “аливаа улстай байгуулсан” гэснийг хасах.

Энэ цэргийн хүчний командлагч биш, командлал байж магадгүй шүү. Тэрийгээ ажлын хэсэг дээрээ дахиад хараарай. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

9.Төслийн 17 дугаар зүйлийг хасах.  
Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

10.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх. Найруулгын санал. Нийлүүлж өөрчлөх.  
Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Найруулгын 2 санал байна.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “хаагчийг” гэснийг “хаагчдыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “цэрэг, цагдаагийн” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч,” гэж, 5.5 дахь хэсгийн “алба хаагч болон цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийн “амь насаа алдсан” гэснийг “нас барсан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “алба хаагч, цэргийн” гэснийг “цэргийн алба хаагч,” гэж, 9.1.5 дахь заалтын “байдлыг” гэснийг “талаар” гэж, 9.1.11 дэх заалтын, мөн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “бие бүрэлдэхүүний” гэснийг “алба хаагчийн” гэж тус тус, 9.1.6, 9.1.9 дэх заалтын, мөн 10.1.4 дэх заалтын “7.1.7-д” гэснийг “7.1.6-д” гэж тус тус, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Батлан хамгаалахын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын” гэснийг “батлан хамгаалахын болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж тус тус өөрчилж, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын, мөн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “эсхүл” гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

12.Төслийн “цэрэг, цагдаагийн алба хаагч” гэснийг “цэргийн болон цагдаагийн алба хаагч” гэж, “цэрэг, цагдаагийн баг” гэснийг “цэргийн болон цагдаагийн баг” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Санал хураалт.

Найруулгын саналуудыг хураалгаж дууслаа. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Найруулгын саналуудыг хураалгаж дуусгалаа.

Эдгээр саналуудыг ажлын хэсэг дээр миний гаргасан саналууд тэгээд

зарчмын зөрүүтэй саналуудыг нэгтгэж хураалгаж дууслаа. Ажлын хэсэг дараа нь тэр нөгөө найруулгын болон эшлэл бусад тэр зүйлүүд дээрээ анхаараарай. Нэгдсэн нэг нэр томъёотой болгоорой гэж.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулья.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.26 дахь заалт нэмсүгэй.

“5.3.26.Цагдаагийн хөгжлийн сан.”гэж нэмэх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай зарчмын зориулалтын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан 1 зарчмын

зөрүүтэй саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн. Гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “эрүүл мэнд” гэснийг “чөлөөлөгдсөн” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цэргийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. Ингээд болчихсон уу? Одоо Эрх зүйн байдлын тухай хууль нь тэ?

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?



Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Энэ зарчмын зөрүүтэй саналгүй тээ?

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Сэргэлэн гишүүн танилцуулъя. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

15.12 цаг

**Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцохоор ирсэн ажлын хэсэг хэвээрээ байгаа тул үргэлжлүүлэн явуулъя.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн зүйлийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан бичгээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирүүлсэн байна. Гишүүний гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулъя.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон санал хураалтыг түр цуцлаарай. Би заалтуудыг нь уншаагүй байна. Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 7.1.22 дахь заалтын “урамишууллыг” гэсний өмнө “мөнгөн” гэж, 2 дахь заалт буюу 8.1.11 дэх заалтын “дарамт шахалт” гэсний дараа “үзүүлэх” гэж тус тус нэмж, мөн заалтын “гадуурхалтаас ангид байх” гэснийг “гадуурхах” гэж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

**“2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэх бүрэлдэхүүн,” гэсний дараа “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар,” гэж нэмсүгэй.”.** Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.3 дахь заалтын “...хилийн отряд, застав болон...” гэснийг “алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбар болон хилийн цэргийн анги,” гэж,” гэснийг хасах. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, 45.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Хөөе энэ чинь нээрээ юу яачихсан байна шүү дээ. Бат-Эрдэнэ гишүүн горимын санал гаргая. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

**Б.Бат-Эрдэнэ:** Миний саналыг эсрэг гарчихлаа. Дахин санал хураалга горимын санал гаргаж байна.

**Б.Энх-Амгалан:** Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын саналыг хүчингүй бол болгож өгөх горимын санал гаргасан. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, горимын санал 54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул төслийн 3 дугаар зүйлийн 7 дугаар хэсгийг дахин хураая. Санал хураалт. Горимын санал дэмжигдсэн. Санал хураалтыг дахиж явуулъя.

Сая дараад байсан чинь энэ миний аппарат бас ажилласангүй. Тийм учраас энэ саналыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна. Горимын саналаар санал хураалт явуулъя.

11 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул төслийн 3 дугаар зүйлийг дахин хураая. Санал хураалт.

Энэ Сэргэлэн гишүүний санал хураалт дахин. Сэргэлэн гишүүний микрофоныг өгье. Та цаад талд нь хийчих. Тэг, тийм цаад талд нь хийгээд явчих. Ажлын хэсэг энэ Ай Ти-гийнханд хэлээрэй. Санал хураалт унаад байна. Ирцэд орчихсон хүмүүс тэгээд яваад байна. Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сэргэлэн:** Миний энэ саяын санал хураалт дээр миний санал хураах төхөөрөмж ажилласангүй. Тэгэхлээр энэ саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

**Б.Энх-Амгалан:** Энэ төслийн 3 дугаар зүйл чинь яасан явахгүй байна. Сэргэлэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас төслийн 3 дугаар зүйлийг дахин санал хураалт явуулъя.

Санал хураалт 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал хураалт. Дууслаа шүү гишүүд ээ.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?



Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын чуулганд Наранбаатар гишүүн танилцуулна.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Дараагийнхдаа оръё. Ажлын хэсгийнхнийг дуудъя.

15.22 цаг

**Эрүүгийн хэрэгт, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Хууль зүйн яамных. Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасны дагуу зөвшилцөж хэлэлцүүлэхээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76.1-д Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Их Хурал соёрхон батлах хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээний эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, шаардлагатай бол түүний орчуулга, гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсвэл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл шаардлагатай бол холбогдох болон хуулийн төслийг Улсын Их Хурал зөвшилцөх, хэлэлцүүлэхээр ирүүлнэ гэж заасан болно.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхээгийн Сүхболд Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал,

Чойжамцангийн Нарантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг. Хэлэлцэж байгаа 4 дүгээр асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Хууль зүйн байнгын хороон дээр асуудал танилцуулж байгаа учраас дараагийнх нь асуудалд ороод танилцуулаад явчихъя. Дараагийн асуудал. Дараагийн асуудал.

**Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ.**

Зөвшилцөх асуудалтай холбогдоод ажлын хэсгийг танилцуулъя. Батмөнхийн Батцэцэг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, Сүхээгийн Сүхболд Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Жамбалдоржийн Соёлмаа мөн яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын дэд захирал.

Төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг танилцуулна. Батцэцэг сайдыг микрофонд урьж байна 2 Номерын микрофоныг өгье. 2 номерын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг өгье. Даралгүй байж бай. 2 Номерын микрофон ажиллахгүй байна уу? Тэгвэл 3 номерын микрофон өгөөдхөөч. 3 номерын микрофоныг өгье. Алив ажлын хэсгийнхнийг нэг юу яагаадхаач. Энэ микрофонууд яагаад ажиллахгүй байна? Алив ажлын хэсгийнхэн, ажлын алба тэр

техникийнхэн рүүгээ ярь. Тэр ажлын хэсгийн микрофон. Ажлын хэсгийн микрофон ажиллачихлаа. Тэн дээр очоод суучих. 3 номерын микрофоныг өгье.

**Б.Батцэцэг:** Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэрэг нь олон улсын эрүүгийн эрх зүйд хамгийн ноцтой гэмт хэргийн төрөлд тооцогддог. Эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, гэмт этгээдүүдийг шийтгэх, улс хоорондын эрх зүйн туслалцааны хамтын ажиллагааг сайжруулахад гэмт этгээдийг шилжүүлэн өгөх олон талт эрх зүйн баримт бичиг байгуулах ажлыг Монгол Улс 2017 оноос идэвхтэй дэмжиж ирсэн бөгөөд Бельги, Нидерланд, Словени, Аргентин, Сенегал улсын хамт конвенцын санаачилгыг урагшлуулах зорилготой үндсэн бүлгийн 7 гишүүн улсын нэгээр ажиллаж байна.

Энэхүү конвенц нь үндсэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр эрсдэхийг хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, төрлөөр устгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц зэрэг уг салбарт хамаарах олон талт олон талт механизмууд байдаг хэдий ч төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийг хянан шийдвэрлэх зохицуулалтыг агуулсан анхны баримт бичиг болох юм.

Энэ хүрээнд уг санаачилгыг өдгөө 80 улс дэмжиж байна. Тус конвенцод гарын үсэг зурах ёслолын арга хэмжээг Нидерландын Гааг хотноо 2024 оны 2 сарын 14-нөөс 5-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 33 улс гарын үсэг зураад байна.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар уг асуудлыг урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлтээ гаргасан. Уг конвенцод гарын үсэг зурах асуудлыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Б.Энх-Амгалан:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэгт баярлалаа.

Хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

**Г.Амартүвшин:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенц төслийг 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын най 14-ний өдрийн хуралдаанаараа дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан болно.

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг Хууль зүйн байнгын хорооны

хуралдаанаар оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийн хэргийг мөрдөн шалгах хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийн зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Амартүвшин гишүүнд баярлалаа. Төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү?

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ,

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны хуралдааны

тэмдэглэлийг санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

Ажлын хэсэгт баярлалаа. Амжилт хүсье.

15.36 цаг

**Ажлын хэсгийг танилцуулсан, хэлэлцэж байгаа асуудал танилцуулчихсан.**

Одоо хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын иргэд олноор зорчдог гадаад улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсаас Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын 1959 оны конвенцод нэгдэн орох тухай хүсэлтийг Европын зөвлөлийн Сайд нарын хороонд гаргаж, тус хороо нь орлогч сайд нарын 2019 оны 13,63 дугаар хурлаар хэлэлцэн дэмжээд урилга ирүүлсэн болно.

Монгол Улс гадаадын 24 улстай байгуулсан 39 хоёр талт гэрээний үндсэн дээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт этгээд ялтан шилжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн байна. Үүнд ихэнх Зүүн Европ болон Азийн улсууд багтаж байна. Харин баруун Европын ихэнх улстай олон улсын конвенцуудад заасан тодорхой төрлийн гэмт хэргээс бусад гэмт хэргийн асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар харилцах боломжгүй байна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцод Европын зөвлөлийн 48



гишүүн улс, Европын зөвлөлийн гишүүн бус 5 улс нэгдэн орсон бөгөөд тус конвенцын гишүүн улсын тоонд Монгол Улсын иргэд суралцах, ажиллах, бизнес болон аяллын зорилгоор олноор зорчдог, оршин суудаг Англи, Герман, Бельги, Ирланд, Швед зэрэг улсууд багтаж байна.

Энэхүү конвенцод нэгдэн орсноор манай улсын хуулийн байгууллагууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой зарим ажиллагааг, тухайлбал, нотлох баримт албажуулж авах, мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох этгээдийг байлцуулах, гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл хэрэгслийг хураан авах гэх зэрэг тодорхой төрлийн ажиллагааг конвенцын гишүүн улсуудын нутаг дэвсгэрт гүйцэтгүүлж тусалцаа авах боломжтой болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу энэхүү конвенц нь заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтад заасны дагуу түүнд гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын олон талт гэрээт бол Засгийн газрын хуралдаанаар тус конвенцод нэгдэн орох саналыг хэлэлцүүлэхдээ түүнийг Соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хамт хэлэлцүүлсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан тусалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хороонд танилцуулж байна.

Хэлэлцэж дэмжиж өгөхийг хүсье.

**Б.Энх-Амгалан:** Энхбаяр сайдад баярлалаа. Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын

гишүүн Сэргэлэн танилцуулна. Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сэргэлэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хэрэгт эрх зүйн тусалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр ирүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан болно.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн тусалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэгт эрх зүйн тусалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Сэргэлэн гишүүнд баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү.

Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

Алга байна. Одоо хуулийн төсөлтэй холбогдуулан санал хураалт явуулна.

Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэнээр аваарай. Төхөөрөмж нь ажиллаагүй байна. Протоколд тэмдэглээд үлдээчихье.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ болон ажлын хэсэгт баярлалаа. Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

15.42 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР